



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬАА

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө 10, Багшийн хөгжлийн ордон,
Утас, факс: (976) 7014 0069, <http://www.itpd.mn>

2018.12.13 № 2/416

танай _____-ны № _____-т

**Сургалтын хуваарь хүргүүлэх
тухай**

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 10 дахь жилдээ ажиллаж буй багш, удирдах болон бусад ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хуваарийг үүгээр мэдэгдэж байна.

Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт нь онлайн ба танхимын 2 хэсэгтэй, онлайн сургалт нь танхимын сургалтын өмнө 5 долоо хоног, нийт 35 хоног үргэлжилнэ. Үндсэн сургалтын хөтөлбөрийг бүрэн судлахын тулд танхимын сургалтын өмнөх онлайн сургалтад заавал хамрагдах шаардлагатайг нийт багш, ажилтнуудад уламжилж, сургууль багш нарт сургалтын хуваарийг мэдэгдэн, хуваарьт хугацаанд нь сургалтад бүрэн хамруулахад анхаарч, хамтран ажиллана уу. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн нийт багш, удирдах болон бусад ажилтнуудын мэдээллийг боловсролын газрын цахим шуудангаар илгээсэн болно.

Энэхүү хуваарьт 10 дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтнуудаас гадна эхний ба 5 дахь жилдээ ажиллаж буй эрүүл мэндийн багш, 5 дахь жилдээ ажиллаж буй дотуур байрын багш, орос, англи хэлнээс бусад гадаад хэлний багш нарын сургалт багтаж байгааг анхаарна уу.

Жич: Тав болон эхний жилдээ ажиллаж буй бусад багш, ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг 2019.03-06 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж байгаа тул хуваарийг хоёрдугаар сард багтааж мэдэгдэх болно.

Хавсралт: Сургалтын хуваарь хуудастай

ДЭД ЗАХИРАЛ



О.ОЮУНТУНГАЛАГ

2018 0784

